

БУЛГАН АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: БУА-2025/138/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2026 он	Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Д.Батцогт Утас 70342580 Цахим хаяг: Battsogtd@audit.gov.mn Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn “Бэйкер Тилли Далайван Аудит” ХХК-ийн Орхон аймаг дахь салбарын захирал: Д.Мягмарсүрэн Утас: 99030170 Цахим хаяг: dalaivan.et@gmail.com “Бэйкер Тилли Далайван Аудит” ХХК-ийн Орхон аймаг дахь салбарын Аудитор: Б.Пүрэвсүрэн Утас: 99921600 Цахим хаяг: dalaivan.orkhon@gmail.com
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2026.02.24. № 222

танай _____ ны № _____ т

СЭЛЭНГЭ СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
Ө.БУЖИНЛХАМ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ сумын эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Сэлэнгэ сумын Эрүүл мэндийн төв нь нийт хэвтэн эмчлүүлэх 7 ортой үйл ажиллагаа явуулж, 2025 онд Эрүүл мэндийн даатгалын тусламж үйлчилгээг давхардсан тоогоор 2196 иргэнд, амбулаторийн үзлэгийг 6308 иргэнд үзүүлэн гүйцэтгэлээр санхүүжин ажиллаж байна. Тайлант онд Эрүүл мэндийн яамнаас 1,360.4 мянган төгрөгийн бараа материал, 12,636.05 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, Булган аймгийн ЭМГ-аас 12,860.8 мянган төгрөгийн бараа материал, орон нутгийн хөгжлийн сангаас 4,750.0 мянган төгрөгийн бараа материал, 32,090.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, орон нутгийн иргэдийн хөрөнгө оруулалтаас 34,469.4 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй авч санхүүгийн тайланд тусгасан.

Аудитын гол асуудал

Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор "Цалин хөлс шинэчлэн батлах тухай" төрийн албан хаагчдын цалин хөлсийг шинэчлэн тогтоосон байна.

2025 онд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 03 "Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай", 04 "Жагсаалт, төлбөрийн

6326050269

хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” тогтоолуудад өөрчлөлт орсон байна. Тус Эрүүл мэндийн төв нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд үйлчлүүлэгчийн биеийн байдалд үнэлгээ өгөх, хянах, эрүүл мэндийг дэмжих, аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэхэд орчин үеийн болон уламжлалт анагаах ухаанд тулгуурлан эмнэлгийн анхан шатны тусламжийг үзүүлэхэд чиглэн үйл ажиллагаа явуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Эрүүл мэндийн төв нь 2025 оны зорилго, зорилтоо тодорхойлон гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж 5 зорилтын хүрээнд 38 арга хэмжээ төлөвлөн сумын Засаг даргаар батлуулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж 2025 оны төлөвлөгөөний биелэлт 94.7 хувьтай дүгнүүлсэн байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй аудитор аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТЦОГТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Эхний үлдэгдэл	2. Эцсийн үлдэгдэл
1	1.1 ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	321,040,129.59	212,023,737.88
31	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,923,556.08	59,218,483.69
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	1,923,556.08	59,218,483.69
31210	Төгрөг	1,923,556.08	59,218,483.69
31211	Төрийн сангийн харилцах	1,923,556.08	59,218,483.69
33	1.1.3 АВЛАГА	181,949,862.87	25,295,826.35
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,400,449.82	237,500
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	180,549,413.05	25,058,326.35
35	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	131,262,710.61	118,411,427.84
35100	Түүхий эд материал	59,326,599.29	66,250,392.55
35110	Тусгай зориулалттай материал	14,759,100	19,091,100
35130	Эм боох материал	44,567,499.29	47,159,292.55
35400	Хангамжийн материал	71,371,111.32	51,571,035.29
35410	Бичиг хэргийн материал	846,700	0.0
35420	Аж ахуйн материал	37,871,150	16,228,700
35440	Түлш, шатах тослох материал	5,904,000	9,098,000
35450	Барилгын засварын материал	179,000	0.0
35460	Хүнсний материал	1,622,610	9,240,494
35470	Бусад хангамжийн материал	30,851,651.32	26,101,841.29
35600	Мал амьтад	565,000	590,000
2	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	641,547,076.01	714,686,326.08
39	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	641,547,076.01	714,686,326.08
39200	Биет хөрөнгө	621,564,076.01	694,838,326.08
39201	Барилга, байгууламж, орон сууц	339,504,537.36	339,504,537.36
39202	Хуримтлагдсан элэгдэл	-114,149,843.12	-123,615,663.38
39203	Авто-тээврийн хэрэгсэл	257,100,801.47	257,100,801.47
39204	Хуримтлагдсан элэгдэл	-49,292,157.38	-65,612,995.88
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	294,886,190.96	376,960,940.96
39206	Хуримтлагдсан элэгдэл	-109,135,353.03	-135,187,424.79
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	10,385,500	52,545,560.71
39208	Хуримтлагдсан элэгдэл	-7,735,600.25	-6,857,430.37
39300	Биет бус хөрөнгө	19,983,000	19,848,000
39301	Програм хангамж	1,350,000	1,350,000
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,035,000	-1,170,000
39303	Бусад биет бус хөрөнгө	19,668,000	19,668,000

Сэлэнгэ сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

3	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	962,587,205.57	926,710,063.96
5	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	962,587,205.57	926,710,063.96
51	Засгийн газрын хувь оролцоо	962,587,205.57	926,710,063.96
51100	Засгийн газрын оруулсан капитал	279,647,290.31	279,647,290.31
511002	Хуримтлагдсан үр дүн	452,000,184.79	416,123,043.18
51200	Өмнөх үеийн үр дүн	452,000,184.79	452,000,184.79
51210	Тайлант үеийн үр дүн	0.0	-35,877,141.61
51220	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	230,939,730.47	230,939,730.47
51300	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	962,587,205.57	926,710,063.96

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Өмнөх он	2. Тайлант он
I	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	1,476,987,905.22	1,299,464,267.25
12	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	322,465,859.7	1,299,464,267.25
120	Нийтлэг татварын бус орлого	322,465,859.7	169,114,902.45
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	803,980	63,561,574.14
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	803,980	63,561,574.14
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	264,130,075.31	86,422,110.71
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	57,531,804.39	19,131,217.6
122	Тусламжийн орлого	0.0	1,130,349,364.8
1221	Хандив тусламж /дотоод/	0.0	1,130,349,364.8
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	0.0	91,004,800
122111	Урсгал санхүүжилтийн орлого\	0.0	91,004,800
12215	Төсөв хоорондын хандив, тусламж	0.0	1,039,344,564.8
122151	Улсын эмнэлгүүдэд ЭМДС-с олгох шилжүүлгийн орлого \ЭМДС-УТ\	0.0	1,039,344,564.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,154,522,045.52	0.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	59,781,400	
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	59,781,400	
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,094,740,645.52	0.0
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,094,740,645.52	0.0
II	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,101,491,041.44	1,247,465,608.86

Сэлэнгэ сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

21	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	1,101,491,041.44	1,247,465,608.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,101,415,041.44	1,184,971,608.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	656,499,932.52	777,308,040.58
210101	Үндсэн цалин	364,078,724.06	406,187,547.22
210102	Нэмэгдэл	239,208,330.46	278,070,568.44
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,529,000	47,162,908
210104	Урамшуулал	38,683,878	45,887,016.92
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд шимтгэл	68,560,905.77	92,781,592.67
210201	Тэтгэврийн даатгалын зардал	48,200,247.2	64,671,662.46
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	5,162,274.74	7,214,828.18
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	2,655,172.83	4,004,852.16
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	2,252,513.46	3,434,434.83
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	10,290,697.54	13,455,815.04
2103	Байр ашиглалт тогтмол зардал	47,375,012.77	57,254,784.58
210301	Гэрэл, цахилгаан	4,552,932.77	7,993,344.58
210302	Түлш, халаалт	41,927,080	47,261,440
210303	Цэвэр, бохир ус	895,000	2,000,000
2104	Хангамж, бараа материалын зардал	50,282,319.05	94,666,660.03
210401	Бичиг хэрэг	3,231,110	5,821,010
210402	Тээвэр, шатахуун	21,780,360	20,394,820
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,862,400	1,890,800
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,048,200	3,372,000
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,169,150	6,236,050
210408	Бараа материал акталсны зардал	18,191,099.05	56,951,980.03
2105	Нормативт зардал	126,491,083.7	100,470,624.94
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	106,603,487.7	85,919,208.94
210502	Хоол, хүнс	19,887,596	14,410,416
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.0	141,000
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,123,386	56,019,150
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,267,837	0.0
210604	Урсгал засвар	17,106,549	56,019,150
2107	Томилолт, зочны зардал	4,055,200	4,348,700
210702	Дотоод албан томилолт	4,055,200	4,348,700
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	63,726,524	18,385,620
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	63,059,228	17,432,570
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.0	450,000
210804	Тээврийн хэрэгслийн татвар	150,000	109,750

Сэлэнгэ сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	49,096	23,000
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	427,400	180,000
210807	Газрын төлбөр	40,800	40,800
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	0.0	149,500
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	115,675,690.4	61,267,770.64
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,370,200	4,200,210
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	112,305,490.4	57,067,560.64
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	328,387.23	72,773,465.42
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.0	10,279,465.42
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\	0.0	10,279,465.42
2132	Бусад урсгал шилжүүлэг	76,000	62,494,000
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.0	59,424,000
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	76,000	3,070,000
III	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	321,619,463.78	-35,812,141.61
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	197,000	65,000
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	197,000	65,000
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	-197,000	-65,000
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	321,422,463,78	-35,877,141,61

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Өмнөх он	2. Тайлант он
I	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	993,799,645,47	1,349,402,025,64
12	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	803,980	1,349,402,025,64
120	Нийтлэг татварын бус орлого	803,980	63,561,574.14
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	803,980	63,561,574.14
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	803,980	63,561,574.14
122	Тусламжийн орлого	0.0	1,285,840,451,50
1221	Хандив тусламж /дотоод/	0.0	1,285,840,451,50
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	0.0	91,004,800
122111	Урсгал санхүүжилтийн орлого\	0.0	91,004,800
12215	Төсөв хоорондын хандив, тусламж	0.0	1,194,835,651.5
122151	Улсын эмнэлгүүдэд ЭМДС-с олгох шилжүүлгийн орлого \ЭМДС-УТ\	0.0	1,194,835,651.5

Сэлэнгэ сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	992,995,665.47	1,285,840,451.5
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	59,781,400	91,004,800
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	59,781,400	91,004,800
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	933,214,265.47	1,194,835,651.5
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	933,214,265.47	1,194,835,651.5
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	996,627,658.11	1,248,322,398.03
21	УРСГАЛ ЗАРДАЛ	996,627,658.11	1,248,322,398.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	996,375,270.88	1,175,618,932.61
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	656,499,932.52	777,308,040.58
210101	Үндсэн цалин	364,078,724.06	406,187,547.22
210102	Нэмэгдэл	239,208,330.46	278,070,568.44
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,529,000	47,162,908
210104	Урамшуулал	38,683,878	45,887,016.92
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	65,690,677.59	91,618,642.85
210201	Тэтгэврийн даатгалын зардал	45,330,019.02	63,508,712.64
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	5,162,274.74	7,214,828.18
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	2,655,172.83	4,004,852.16
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	2,252,513.46	3,434,434.83
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	10,290,697.54	13,455,815.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	53,279,012.77	60,448,784.58
210301	Гэрэл, цахилгаан	4,552,932.77	7,993,344.58
210302	Түлш, халаалт	47,831,080	50,455,440
210303	Цэвэр, бохир ус	895,000	2,000,000
2104	Хангамж, бараа материалын зардал	37,463,010	50,277,880
210401	Бичиг хэрэг	3,134,250	5,104,260
210402	Тээвэр, шатахуун	21,780,360	20,394,820
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,544,400	2,183,300
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,989,900	3,012,000
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,014,100	19,583,500
2105	Нормативт зардал	93,664,465	105,478,974.6
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	75,398,965	75,650,174.6
210502	Хоол, хүнс	14,515,500	22,028,300
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,750,000	7,800,500
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,561,549	58,243,910
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,526,000	2,403,760
210602	Тавилга	0.0	0.0

Сэлэнгэ сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

210604	Урсгал засвар	11,035,549	55,840,150
2107	Томилолт, зочны зардал	4,055,200	4,348,700
210702	Дотоод албан томилолт	4,055,200	4,348,700
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	56,907,124	20,791,870
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	55,516,228	19,335,970
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.0	450,000
210804	Тээврийн хэрэгслийн татвар	150,000	109,750
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	49,096	23,000
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	427,400	180,000
210807	Газрын төлбөр	40,800	40,800
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	723,600	652,350
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,004,300	7,102,130
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,004,300	7,102,130
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.0	62,424,000
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.0	10,279,465.42
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\	0.0	10,279,465.42
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.0	62,424,000
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.0	59,424,000
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.0	3,000,000
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-2,828,012.64	101,079,627.61
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	12,611,350	43,784,700
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	12,611,350	43,784,700
2200	Дотоод эх үүсвэрээр	12,611,350	43,784,700
222001	Тоног төхөөрөмж	0.0	24,788,700
223001	Бусад хөрөнгө	0.0	18,996,000
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	12,611,350	0
VI	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-12,611,350	-43,784,700
VIII	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-15,439,362.64	57,294,927.61
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	17,362,918.72	1,923,556.08
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,923,556.08	59,218,483.69

Сэлэнгэ сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Дансны нэр, төрөл	1. Устгалын өмнөх			
	1.1 Засгийн газрын оруулсан капитал	1.2 Дахин үнэлгээний нөөц	1.3 Хуримтлагдсан үр дүн	1.4 Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	279,647,290.31	230,939,730.47	130,577,721.01	641,164,741.79
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	279,647,290.31	230,939,730.47	130,577,721.01	641,164,741.79
Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	315,518,463.78	315,518,463.78
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	279,647,290.31	230,939,730.47	452,000,184.79	962,587,205.57
2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	279,647,290.31	230,939,730.47	452,000,184.79	962,587,205.57
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	279,647,290.31	230,939,730.47	452,000,184.79	962,587,205.57
Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	-35,877,141.61	-35,877,141.61
2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	279,647,290.31	230,939,730.47	416,123,043.18	926,710,063.96

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Төлөвлөгөө	2. Гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,296,617,051.5	1,349,402,025.64
12	Татварын бус орлого	1,296,617,051.5	1,349,402,025.64
120	Нийтлэг татварын бус орлого	0	63,561,574.14
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого	0	63,561,574.14
122	Тусламжийн орлого	1,296,617,051.5	1,285,840,451.5
122001	Хандив тусламж /дотоод/	1,194,835,651.5	1,194,835,651.5
122005	Төсвөөс санхүүжих	101,781,400	91,004,800
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН	1,421,865,400	1,201,102,298.03
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,421,865,400	1,201,102,298.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,420,446,200	1,175,618,932.61
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	856,611,500	777,308,040.58
210101	Үндсэн цалин	406,759,000	406,187,547.22
210102	Нэмэгдэл	331,338,200	278,070,568.44
210103	Унаа хоолны хөнгөлөлт	46,319,700	47,162,908
210104	Урамшуулал	72,194,600	45,887,016.92
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	106,806,600	91,618,642.85
210201	Тэтгэврийн даатгал	71,937,900	63,508,712.64
210202	Тэтгэмжийн даатгал	8,717,200	7,214,828.18
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,358,600	4,004,852.16
210204	Ажилгүйдлийн даатгал	4,358,600	3,434,434.83
210205	Эрүүл мэндийн даатгал	17,434,300	13,455,815.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	61,004,800	60,448,784.58
210301	Гэрэл, цахилгаан	8,000,000	7,993,344.58
210302	Түлш, халаалт	51,004,800	50,455,440
210303	Цэвэр, бохир ус	2,000,000	2,000,000
2104	Хангамж, бараа материалын зардал	63,577,600	50,277,880
210401	Бичиг хэрэг	6,153,900	5,104,260
210402	Тээвэр, шатахуун	32,224,000	20,394,820
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,561,200	2,183,300
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,016,100	3,012,000
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	19,622,400	19,583,500
2105	Нормативт зардал	151,352,500	105,478,974.6
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	108,958,800	75,650,174.6

Сэлэнгэ сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

210502	Хоол, хүнс	33,643,500	22,028,300
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,750,200	7,800,500
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	110,798,500	81,752,060
210601	Багаж, техник, хэрэгсэл	38,356,600	27,192,460
210602	Тавилга	25,400,000	18,996,000
210604	Урсгал засвар	77,041,900	55,840,150
2107	Томилолт, зочны зардал	7,000,000	4,348,700
210702	Дотоод албан томилолт	7,000,000	4,348,700
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,814,800	20,791,870
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22,920,300	19,335,970
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000	450,000
210804	Тээврийн хэрэгслийн татвар	150,000	109,750
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,000	23,000
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	431,100	180,000
210807	Газрын төлбөр	40,800	40,800
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	723,600	652,350
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,479,900	7,102,130
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,479,900	7,102,130
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	92,424,000	72,703,465.42
2132	Бусад урсгал шилжүүлэг	92,424,000	62,424,000
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	30,000,000	0.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	59,424,000	59,424,000
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,000,000	3,000,000
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-2,597,200	47,294,927.61
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,597,200	-47,294,927.61
7	3 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	2,597,200	-47,294,927.61
4	4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	1,923,556.08
5	5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	59,218,483.69

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 18,726.7 мянган төгрөгийн 1 алдаа 4 зөрчил¹ илэрснээс 640.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 3 зөвлөмж хүргүүлсэн болно.

Залруулсан алдаа:

- Санхүүгийн үр дүнгийн тайланд 1,810.1 мянган төгрөгийн бусад бараа ажил үйлчилгээний зардлыг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжид зардал гүйлгэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5."батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"; Сангийн сайдын 2023 оны 221 тушаалаар батлагдсан " ангилал шинэчлэн батлах тухай журам"-ын 2-р хавсралтын Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал зөрчигдсөн байна

3.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт: Албан хаагчийн хоол, унааны нэмэгдлийг албан томилолтоор ажилласан хугацаанд давхардуулан 640.0 мянган төгрөг илүү тооцож олгосон нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.3-д "Гүйцэтгэж байгаа албан үүргийн шинж байдлаас хамааран зохих журмын дагуу албаны унаа хэрэглэх, ажилдаа ирэх, буцах төрийн тээврийн хэрэгслийн зардлын зохих хэсгийг нөхөн авах" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөөгүй.

3.3 Зөвлөмж

1. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Аймгийн оны шилдэг байгууллагаар шалгарсантай холбогдуулан гаргасан байгууллагын даргын 2025 оны 04сарын 17-ний өдрийн Б/10 тоот тушаалаар нийт 13,475.6 мянган төгрөгийн урамшууллыг улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-д "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэж заасныг зөрчсөн байна

Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2.Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын дарга ажилчдын нийгмийн баталгааг хангах тухай тушаал гарган 2,211.0 мянган төгрөгийг эм бэлдмэл эмнэлэгийн хэрэгслийн данснаас зарцуулсан, ажилчдын нийгмийн баталгааг хангах тушаалын хуулийн заалт ажилчдыг шагнаж урамшуулах, ажлын үр дүнг харгалзан урамшуулах заалтуудыг үндэслэл болгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5."батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"; 41 дүгээр зүйлийн 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах" Сангийн сайдын 2023 оны 221 тушаалаар батлагдсан " ангилал шинэчлэн батлах тухай журам"-ын 2-р хавсралтын "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал" зэрэг зөрчигдөж байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах.

3.Хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Мал амьтдын дансанд хурга 5.0 мянган төгрөг, 2 болон 3 настай хонь 18.0 мянган төгрөгийн үнэлгээтэй байгаа нь зах зээлийн үнээс хэт доогуур үнэлгээтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4."үнэн зөв байх", 5 дугаар зүйлийн 5.1.5."хэмжигдэхүйц байх", Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалын "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 1 хавсралтын "12.8, 12.9, 12.10 "зэрэг заалтууд зөрчигдөж байна

Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ гэж заасны дагуу аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 6 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Зардал гүйлгэн зарцуулсан	1	1,810.1					1	1,810.1				
Дүн	1	1,810.1					1	1,810.1				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Томиллолтоор ажилласан ажилчдад хоолны мөнгө нэмж олгосон	1	640.0	1	640.0								
Хуулийн үндэслэл буруу тушаалаар урамшуулал олгосон	1	13,475.6					1	13,475.6				
Зардал гүйлгэн зарцуулсан	1	2,211.0					1	2,211.0				
Мал амьтдын бүртгэл зах зээлийн үнэлгээнээс хэт доогуур үнэлгээтэй байна.	1	590.0					1	590.0				
Дүн	4	16,916.6	1	640.0				16,276.6				